



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 8/09

Өвт

Коронавируст халдварт (Covid-19) -ын
үед нэмэлтээр ор дэлгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр хуулийн 59.1.1 дэх заалт, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.5, 10.4.4, 18 дугаар зүйлийн 18.4, 32 дугаар зүйлийн 32.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварт (Covid-19)-ын үед нэмэлтээр ор дэлгэх эмнэлэг, байрыг хавсралтаар баталсугай.
2. Нэмэлтээр ажиллах эмнэлэг, байрны эмч, мэргэжилтэн, ажилтныг сургаж дадлагажуулах, эм эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал халдвартгүйтгэлийн бодисны нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Х.Цэдэндорж)-д үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны "Коронавируст халдварт (Covid-19) -ын үед нэмэлтээр ор дэлгэх, цар тахалтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай" А/139 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



621101017
D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

Сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны
өдрийн А/09 дүгээр захирамжийн хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ҮЕД ДЭЛГЭХ ОР,
ЭМНЭЛГИЙН БАЙР

Д/д	Байрны нэр	Орны тоо
1	Хуучин эмнэлгийн байр	60
2	Халдвартын	3
3	80 хүүхдийн дотуур байр	40
4	Спорт заал	100
5	"Соёмбо" буудал	12
6	"Эх нутаг" буудал	7
	бүгд	222

--оOо--